БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН
ӨРТӨГ ТӨЛБӨРИЙН АРГА, СУДАЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЭРДЭНИЙН УУГАНЦЭЦЭГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.** | | | | | | | |
| 1. | ***Арга хэмжээ 1.2.1*** Сонгосон эрүүл мэндийн байгууллага, тусламж, үйлчилгээний өртөг тооцоход шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэж боловсруулж, хамтран ажиллана. | ЭМБ-ын тоо, хамруулсан тусламж, үйлчилгээний нэр төрөл, боловсруулалт хийсэн мэдээллийн тоо | Өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийн үнийн судалгааг сонгогдсон ХӨСҮТ, эмнэлгүүдэд хийсэн | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 705 ОХБ-т өртөгийн тооцоолол хийгдсэн байна. | 1.ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолын шинэчлэлийн хүрээнд Хавдар судлалын үндэсний төв эмнэлгээс ирүүлсэн нөхөн сэргээх мэс засал хийлгэсэн нийт 216 өвчтөний түүхээс өндөр өртөгтэй хэрэгслийн тоо, өртөг, эм, эмч, сувилагчийн үзлэгийн тоо, оношилгоо шинжилгээ хийлгэсэн төрөл, бусад зардал тус бүрийг дэлгэрэнгүй гарган өртгийн тооцоололд оруулах зардлын задаргааг нэгтгэн боловсруулсан.<br>2.Цаг үеийн тулгамдсан халдварт өвчний нэг болох улаан бурхан өвчлөлийн тархалт, түүнээс үүдэлтэй эрүүл мэндийн салбарын эдийн засгийн ачааллыг тодорхойлох зорилгоор өргөн хүрээний өртгийн тооцооллын судалгааг хийсэн. Энэхүү судалгааны хүрээнд Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв (ХӨСҮТ), Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өмнөговь аймгийн Бүсийн Оношилгоо, Эмчилгээний Төв (БОЭТ) зэрэг 3 эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нийт 237 улаан бурхан өвчтэй өвчтөний эмнэлгийн түүх, эмчилгээний үйл явцад суурилсан өртгийн дэлгэрэнгүй тооцоог хийсэн. | 2025.01.31<br>2024.05.31 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | ***Арга хэмжээ 1.3***<br>ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд сар бүр дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулна. | -Дата анализ хийгдсэн тоо<br>-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ЭМД-ын тусламж, үйлчилгээний 2023 оны гүйцэтгэлийн мэдээг боловсруулсан. | ЭМД-ын тусламж, үйлчилгээний 2024 оны гүйцэтгэлийн мэдээг 12 сараар гарган боловсруулсан. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоолын хүрээнд лавлагаа шатлалын болон сумын эрүүл мэндийн төвийн үзүүлсэн тусламж,үйлчилгээний тоон мэдээлэлийг 2025 оны 1-3 сарын байдлаар гарган дүн шинэжилгээ хийж боловсруулсан. Үүнд:<br>• Амбулаторийн тусламж, үйлчилгээ<br>• Диализын тусламж, үйлчилгээ<br>• Өдрийн эмчилгээ<br>• Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ<br>• Сувиллын тусламж, үйлчилгээ<br>• Сэргээн засах тусламж,үйлчилгээ<br>• Уламжлалтын тусламж,үйлчилгээ<br>• Телемедициний тусламж, үйлчилгээ<br>• Түргэн тусламж<br>• Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ<br>• Яаралтай тусламж<br>• Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ тус бүрээр төрийн өмчийн болон хувийн хэвшлийн ЭМБ-аар, ОХБ-ээр, даатгуулагчийн төрөл, нас хүйсээр тоон мэдээллийг 1-3 сарын байдлаар гарган боловсруулсан. | 2025.01.01<br>2025.03.31 | 90% |
| 3. | **Арга хэмжээ 1.4**<br>ЭМДС-ийн статистик мэдээллийг эмхэтгэл болгон хэвлүүлж олон нийтийг мэдээллээр хангана. | Эмхэтгэлийн тоо<br>-Цахим хандалтын тоо | Эрүүл мэндийн даатгалын 2022-2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийг бэлтгэсэн. | Эрүүл мэндийн даатгалын 2023-2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийг бэлтгэсэн. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын А/32 дугаартай "Аулын хэсэг байгуулах тухай " тушаалын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны статистик мэдээ боловсруулах, эмхэтгэх чиг үүргийн хүрээнд ажлын хэсгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>• Нэг даатгуулагчид ногдох эрүүл мэндийн тусламж,үйлчилгээний дундаж зардал,насны бүлгээр | 2025.01.30<br>2025.05.31 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж,үйлчилгээний гүйцэтгэл,нэр төрлөөр<br>• Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж,үйлчилгээний гүйцэтгэл,эрүүл мэндийн байгууллагын төрлөөр<br>• Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж,үйлчилгээ авсан даатгуулагчдын үзүүлэлт үр дүн<br>• Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал.<br>• Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийн байдал<br>• Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо харьцуулалт | | |
| **Зорилго 3. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| **Зорилт 3.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.** | | | | | | | |
| 1. | ***Арга хэмжээ 3.1***<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу хэрэгжүүлнэ. | Албан бичиг шийдвэрлэлтийн хувь, | 95.2 | 99 | 1.Албан бичиг<br>Ирсэн- 24, Явсан- 14<br>(хариу хүргүүлэх тухай -13)<br>2.Дотоод албан бичиг (Мэдээлэл авах тухай)-6<br>3.Архивын нэгж бүрдүүлэлт:<br>2024 онд хөтлөгдөж дууссан албан хэргээр нийт 4 архивын нэгжийг бүрдүүлж байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. | 2025.01.01<br>2025.05.31 | 100% |
| 2. | ***Арга хэмжээ 3.2***<br>Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай | Мэдүүлвэл зохих мэдүүлгийн тоо | 2024 оны ХАСХОМ мэдүүлсэн байна | 2024 оны ХАСХОМ мэдүүлсэн байна | 2024 оны ХАСХОМ-ийг бөглөн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. | 2025.01.01<br>2025.02.11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн хэрэгжилтийг хангаж | | | | | | |
| 3. | ***Арга хэмжээ 3.5*** Төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын нэгжүүдийг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана. | Хүргүүлсэн чиглэл, сургалтын тоо | 23 | 25 | 1.ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоол,2024 оны 05, 06 дугаар тогтоолыг шинэчлэн баталсан тогтоолын танилцуулга, сургалтын хөтөлбөрийг бэлтгэсэн. Мөн орон нутгийн даатгалын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн дунд нийт 140 хүнд сургалтыг зохион байгуулж, хурлын протоколыг хийж гүйцэтгэсэн.<br>2.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03, 05, 10 дугаар тогтоолуудын танилцуулга, 4 удаагийн сургалтыг төв орон нутгийн эрүүл мэндийн даатгалын нэгжийн албан хаагчдад зохион байгуулж, хэлэлцүүлгийн бүртгэл болон протоколыг хөтлөн ажилласан. | 2025.01.01<br>2025.03.31 | 90% |
| 4. | ***Арга хэмжээ 3.6*** Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн санал, гомдлыг шуурхай шийдвэрлэнэ. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах" 11-11 төвд ирсэн санал, гомдлыг 100 хувь барагдуулсан. | "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн санал, гомдлыг хүлээн авч бүрэн барагдуулан ажилласан байна. | • Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах-1111" төвөөс ирсэн нийт **5** санал, гомдлыг шуурхай шийдвэрлэн ажилласан байна.<br>• Лавлах утас болох 70101157 дугаараар холбогдсон иргэд болон эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр мэдээлэл зөвлөгөөг өгч гомдлыг боломжтой тохиолдолд тухай бүр шийдвэрлэн ажилласан байна. | 2025.01.31<br>2025.03.31 | 90% |
| 5. | **Арга хэмжээ 3.7** Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, дотоод ажил үүрэг, цаг үеийн ажлуудад идэвхтэй оролцож үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана | Үүрэг даалгаврын тоо | Цаг тухай бүр өгсөн үүрэг, даалгаврыг гүйцэтгэж, ажлын хэсэгт орж ажилласан байна | Цаг тухай бүр өгсөн үүрэг, даалгаврыг гүйцэтгэж, 2 ажлын хэсэгт орж ажилласан байна. | **БТГ-ын дотоод ажил**<br>• Шуурхай хурлаар шийдвэрлэгдсэн биелэлтийн дагуу БТГ-ын хурлын тэмдэглэл, 7 хоног, дотоод албан бичгийг бүртгэн ажилласан.<br>• Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулсан.<br>• Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлын 2025 | 2025.01.01<br>2025.05.31 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны хурлын шийдвэрийн биелэлтийг нэгтгэн боловсруулсан.<br>**Цаг үеийн судалгааны ажил**<br>• ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолын өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой нэн шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээ өргөжиж, зарим тусламж, үйлчилгээ саарч байгаад үндэслэн дараах дүн шинжилгээ хийж боловсруулсан. Үүнд:<br>- Нэн шаардлагатай, нэн шаардлагатай бус тусламж, үйлчилгээний тоон мэдээг 2020-2024 оны 1-12 сарын байдлаар гарган боловсруулсан.<br>- Хамтын төлбөрөөс чөлөөлөгдсөн даатгуулагчийн тоон мэдээллийг 2022-2024 оны 1-12 сарын байдлаар гарган боловсруулсан.<br>- Жилд 2 сая төгрөгөөс дээш санхүүгийн хамгаалалт авсан иргэдийн тоо, санхүүжилтийн байдлыг гарган танилцуулгыг бэлтгэн боловсруулсан.<br>• Аудитын газраас явуулж буй шалгалтын хүрээнд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, холбогдох мэдээллийг цахим мэдээллийн сангаас гаргасан. Үүнд: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэрээр, нэхэмжилсэн даатгуулагчийн тоог давхардалгүй хэлбэрээр, тохиолдлын тоо болон санхүүжилтийн олгохоор тооцсон мөнгөн дүн зэрэг мэдээллийг 2022-2024 оны байдлаар гарган боловсруулсан.<br>• Аудитын газраас явуулж буй шалгалтын хүрээнд нэг эх үүсвэрээр бэлтгэсэн эмийн нэгжийн үнийг харьцуулсан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | судалгааны нэгтгэлийг хийж гарган боловсруулсан.<br>• 2022- 2024 оны үйл ажиллагааны тайлангийн харьцуулсан тоо мэдээг нэгтгэн боловсруулж тамгын газарт хүргүүлсэн.<br>• Лавлагаа шатлалын нийслэлд үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүд болон ГССҮТ-ийн яаралтай тусламж, үйлчилгээний 2023-2024 оны тохиолдлын тоо, оношийн хамааралтай бүлэг, санхүүжилтийн мэдээллийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр боловсруулсан.<br>• Монгол улсын 6 бүсийн хүрээнд хавдрын оношоор тусламж,үйлчилгээ авсан даатгуулагчийн тоон мэдээллийг хүний тоо, тохиолдлын тоо, олгосон санхүүжилтийг аймаг, нийслэлээр 2023-2024 оны байдлаар гарган боловсруулсан.<br>• L89, S12,S22,S32, I60-69 оношын хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон тоон мэдээллийг 2024 оны байдлаар гарган ЭМЯ-нд цахимаар хүргүүлсэн.<br>• Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тоон мэдээллийг тусламж, үйлчилгээний төрөл болон оношийн хамааралтай бүлэг (ОУӨА-10)-ийн үйлдэл тус бүрээр, тохиолдлын тоог 2023-2024 оны байдлаар гаргасан тоон мэдээллийг хавсралтаар 2025.01.23-ны өдрийн 01/229 тоот албан бичгийг ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>• Засгийн Газрын 232 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тайлан, 1-3 сарын тоон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээг тогтмол гарган ОНХХ-т хүргүүлэн opendata.gov.mn сайтад байршуулсан.<br>• Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн 2025 оны төсвийн санхүүжилтийг 2024 оны жилийн төсөвтэй харьцуулсан мэдээллийг гарган 2025 оны 03 сарын 28-ны өдрийн 01/747 албан тоот бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>• Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдийн тохиолдол болон санхүүжилтийн мэдээллийг 2022-2024 оны байдлаар гарган нэгтгэж 2025 оны 04 сарын 28-ны өдрийн 04/1080 албан тоот бичгээр ХБХХЕГ-т хүргүүлсэн.<br>• Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүргүүлэх саналыг 2025 оны 05 сарын 28-ны өдрийн 01/1370 албан тоот бичгээр хүргүүлсэн.<br>**ППТ бэлтгэх ажил**<br>• Дархан, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Завхан, Увс, Ховд аймгуудын ЭМБ-ын үзүүлж буй тусламж, үйлчилгээ, санхүүжилттэй холбоотой танилцуулгыг бэлтгэсэн. Үүнд:<br>• Гэрээт ЭМБ-ын тоог 2025 оны байдлаар, ЭМДС-аас олгосон санхүүжилтийг 2021-2025 оны байдлаар<br>• ЭМДС-аас аймгийн ЭМБ-д олгосон санхүүжилт 2025 оны 1-2 сарын байдлаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Аймгийн ЭМБ-ын тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, санхүүжилт<br>• Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тус тус гарган боловсруулсан. | | |
| 6. | ***Арга хэмжээ 3.6***<br>Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоол, тушаал, журмын талаар гэрээтэй ЭМБ-дад сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагааг зохион байгуулна. | Сургалтын тоо | Гэрээтэй ЭМБ-дад | ЭМБ-дад дэмжин туслах үйл ажиллагаа зохион байгуулж, сургалт хийсэн байна. | ЭМДҮЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар ЭМДҮЗ-ийн 2024 оны 06, 05, 2023 оны 10 дугаар тогтоолуудын шинэчилсэн төслийг хэлэлцүүлж батлуулсан. Энэхүү тогтоолууд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор бүх газар, хэлтсүүдийн тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хийх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/07 дугаар тушаалаар батлуулсан.<br>Мөн шинэчлэн батлагдсан тогтоолын өөрчлөлтийн талаар танилцуулга, сургалт хийх төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу цахим болон танхимийн хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан. Үүнд:<br>02 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолыг танилцуулах, сургагч багш бэлтгэх сургалтыг ЭМБ-ын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танхимаар зохион байгуулсан бөгөөд сургалтад нийслэлийн 25 байгууллагын 95 удирдлага, албан хаагчид оролцсон нийт 219 ажилтан, албан хаагчдад танхимаар, цахимаар сургалт зохион байгуулж асуулт хариулт, протоколыг бичиж нэгтгэн хүргүүлсэн. | 2025.01.01<br>2024.02.28 | 90% |
| 7. | ***Арга хэмжээ 3.7***<br>ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ | Тогтоолын хэрэгжилтийн тайлан хүргүүлсэн | Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний | Тогтоолын хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн | 1.ЭМДҮЗ-ийн ажлын албанд 2024 оны 05, 06 дугаар тогтоолуудын хүрээнд лавлагаа шатлалын болон сумын эрүүл мэндийн төвийн хэрэгжилтийн тайланг 2024 оны | 2025.01.31<br>2025.02.28 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, ЭМДҮЗ-ийн ажлын албанд хүргүүлж ажиллана. | | тогтоол, эмийн үнийн хөнгөлөлтийн хэрэгжилтийн тайланг гаргаж хүргүүлсэн. | байдлаар гаргаж хүргүүлсэн байна. | жилийн эцсийн байдлаар гарган ЭМДҮЗ-ийн ажлын албанд 2025 оны 02 сарын 12-ны өдрийн 01/399 албан тоот бичгээр хүргүүлэн ажилласан.<br>2.ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон хэрэгжилтийн тайланг 2023, 2024 оны байдлаар ЭМДҮЗ-ийн ажлын албанд хүргүүлэн ажилласан.<br>3.ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолын хүрээнд Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгийн хэрэгжилтийн тайланг 2024 оны жилийн эцсийн байдлаар хүргүүлэн ажилласан.<br>4.ЭМДҮЗ-ийн ажлын албанд 2024 оны 05 дугаар тогтоолын хүрээнд Анхан шатны тусламж, үйлчилгээнии гүйцэтгэлийн хэрэгжилтийн тайланг 2024 оны жилийн эцсийн байдлаар хүргүүлэн ажилласан.<br>5.Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2025 оны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтын саналыг газар, хэлтсүүдээс авч нэгтгэн боловсруулж 2025 оны 02 сарын 13-ны өдрийн 01/411 албан тоот бичгээр ЭМДҮЗ-ийн ажлын албанд хүргүүлсэн. | | |

## ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | ***Арга хэмжээ 2.1*** Өөрийн эрхэлсэн ажлын хүрээнд гарсан бодлогын баримт | Сургалтад хамрагдсан байна. | Сургалтад хамрагдсан байна. | Ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр мэдлэг олгох сургалтад хамрагдсан байна. | Дэлхийн банкнаас зохион байгуулсан ДЭМБ-ын зөвлөх nice-ийн 3 удаагийн сургалтад хамрагдсан. | 2025.01.02 2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бичиг, хууль тогтоомж, тушаалыг уншиж судлах | | | | -Байгууллагаас зохион байгуулсан 3 удаагийн сургалт, арга хэмжээнд тогтмол хамрагдсан.<br>-Чиг үүргийн хүрээнд явагдсан сургалтуудыг зохион байгуулахад идэвхтэй оролцож ажилласан. | | |
| 2. | ***Арга хэмжээ 2.2*** Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй ээлжилт сургалт | Хамрагдсан сургалтын тоо | ТАЗ-ийн 9 удаагийн цахим сургалтад хамрагдсан. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан болон хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдана. | Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гаригт зохион байгуулдаг "Вебинар" онлайн сургалтад 6 удаа хамрагдсан. | 2025.01.02<br>2024.05.31 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 2.3** Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан болон хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | "Монгол бичиг"-ийн 16 удаагийн цахим сургалт бусад 2 танхимын сургалтад хамрагдсан. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан болон хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдана. | Албан хаагчдад танин мэдэхүйн чиглэлээр ажил амьдралд ашиглагдахуйц мэдээллийг өгөх зорилгоор 14 хоног тутам зохион байгуулдаг "Мэдээллийн цаг"-т 4 удаа оролцсон. | 2025.01.02<br>2025.05.31 | 100 |

**ТАЙЛАН БИЧСЭН:**
ӨРТӨГ ТӨЛБӨРИЙН АРГА, СУДАЛГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН .......................... (Э.УУГАНЦЭЦЭГ) ................................(*огноо*)

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**
ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТ,
СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ .......................... (Б.УУГАНБАЯР) ............................... (*огноо*)